

## ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ ХЭРХЭН ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА ТАЛААР ЯРИЛЦЛАА

2010.09.18 № 222 /3612/ - рт

**“Өдрийн сонин”-ы “Асуух эрхийн танхим”-д болдог ээлжит нээлттэй ярилцлагаар энэ удаа хэвлэлийн эрх чөлөөний тухай сэдвийг хөндсөн. Хэвлэл мэдээллийнхэн бичсэн, нийтэлсэн зүйлийнхээ төлөө шүүхэд дуудагдаж, цагдаагийн хаалга сахиж суух нь ихэссэн өнөө үед Хэвлэлийн эрх чөлөөний хууль хэрхэн хэрэгжиж байгаа, сэтгүүлчдийн эрх ашиг яаж зөрчигдөж байгаа талаар хэлэлцүүлэгт уригдсан бүхэн санал бодлоо солилцсон юм.**

Нээлттэй ярилцлагад Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн хүндэт ерөнхийлөгч Ц.Дашдондов, Гүйцэтгэх хорооны гишүүн М.Зулькафил, “Глоб Интэрнэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн Х.Наранжаргал, “Нийгмийн толь” сонины эрхлэгч С.Энхтуул, “Нийслэл таймс” сонины орлогч эрхлэгч Г.Дашрэнцэн, Өвөрхангай аймгийн сонины эрхлэгчээр ажиллаж байсан Б.Жавзансүрэн, “Өглөөний сонин”-ы сэтгүүлч Х.Намуун-Уянга болон бусад хэвлэл мэдээллийнхэн оролцсон.

“Өдрийн сонин”-ы Хариуцлагатай нарийн бичгийн дарга **Д.ОЮУНТУЯА** нээж үг хэлсэн. Тэрээр “Сүүлийн үед хэвлэл мэдээллийн байгууллагынхны эрх ашиг ихээр зөрчигдөж, шүүх цагдаад дуудагдах болсон. Энэ тал дээр манай сонин анхаарал хандуулж, асуулга тавихаар та бүхнийг урьсан юм” хэмээн онцолсон.

Нээлттэй ярилцлагын эхний асуултыг “Өдрийн сонин”-ы Эрэн сурвалжлах, тоймчдын албаны дарга **Д.МӨНГӨНДАЛАЙ** тавьсан. “Хэн нэгэн албан тушаалтны буруу үйл ажиллагаа, авлига хээл хахуультай холбоотой мэдээлэл зэрэг нийгэмд болж бүтэхгүй байгаа зүйлийн талаар шүүмжлэлтэй хандсанаа төлөө сэтгүүлчид өөрсдөө асуудалд ордог. Энэ тухай бид өмнө нь олонтаа хөндөж байсан ч дорвитой шийдэлд хүрээгүй байгаа.

Тиймээс хэвлэл мэдээллийнхнийгээ цуглуулаад ялангуяа эрх нь зөрчигдөж байсан сэтгүүлчид та бүхэнтэй хэвлэлийн эрх чөлөөний хуулийн талаар нээлттэй ярилцах гэсэн юм. Өнөөдөр манайд хэвлэлийн эрх чөлөөний хууль хэрхэн зөрчигдөж байна вэ” гэх түүний асуултад уригдсан зочид доорхи хариултыг өгсөн юм.

**Х.НАРАНЖАРГАЛ:** Энэхүү нээлттэй ярилцлагад оролцож байгаадаа баяртай байна. Яагаад гэхээр сэтгүүлч та бүхэн бусдын эрх ашгийн төлөө үргэлж тэмцдэг хэрнээ өөрсдийнхөө төлөө дуугардаггүй. Хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр жилдээ ганц дуугарах нь бий. Манай Ц.Дашдондов гуайн хэлсэн үг байдаг. “Хэвлэлийн эрх чөлөөг төр засагтай амраглаж байж олдоггүй, харин байлдаж тэмцэж байж олдог” гэж. Тэгэхээр ийм хүчтэй зэвсгийг гартаа атгасан сэтгүүлчид маань өөрсдийнхөө төлөө, хэн нэгнийхээ төлөө дуу хоолойгоо нэгтгэхгүй байна аа гэдэг маань ерөнхийдөө биш болж байгаагийн илэрхийлэл. Д.Мөнгөндалай дарга “Өнөөдөр манайд хэвлэлийн эрх чөлөөний хууль хэрхэн зөрчигдөж байгаа” талаар асуулаа. Уг асуулттай уялдуулж хэдхэн хоногийн өмнө уншигчийн захидал нийтэлснийхээ төлөө буруудаад байгаа “Нийгмийн толь” сонины асуудлаар манай байгууллага байр сууриа илэрхийлэх гэсэн юм. Хэлэлцүүлэгт тус сонины эрхлэгч ч ирсэн байна.

Бид Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, хурандаа Ганхүү нарт эсэргүүцлийн захидал илгээсэн байгаа. Тэрхүү захидалд уг сонин гол компьютерийг булаан авсан, авахдаа лацдах юм уу, ямар нэгэн тамга тэмдэг тавиагүй, редакцийн зүгээс компьютерт байгаа мэдээллээ авъя гэх тэрхүү саналыг хүлээж аваагүй зэрэг нь тодорхой зорилготой үйлдэл биш байгаа гэсэн эргэлзээг төрүүлснээ дурдсан.

Ер нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхэд нь зарим иргэдэд хамгаалал хэрэгтэй болдог. Тиймээс сонин хэвлэл, телевиз радиогийнхонд мэдээлэгчийг хамгаалах, эх сурвалжаа нууцлах хууль, эрхзүйн баталгаа байна. Аливаа төрийн байгууллага болон бусад газруудад бугшсан авлига, хээл хахуулийг илчилчиж байгаа иргэн хүнийг дандаа эрсдэл дагадаг. Иргэнээ хамгаалах үүднээс ардчилсан нийгэмд уг хамгаалалтыг бий болгодог юм. Харамсалтай нь манайд хуулийн хүрээнд баталгаажаагүй байна. Яагаад баталгаажихгүй байна гэхээр төр засгийн удирдлага, эрх мэдэлтнүүдтэй шууд холбоотой. Тэд албан тушаалаа ашиглаж хэвлэл мэдээллийнхнийг дарамталдаг, сүрдүүлдэг.

Өөрсдийнхөө нэр хүндийг сэргээж, олон нийтэд төөрөгдөл төрүүлдэг. “Нийгмийн толь” сонин дээр гарсан захидал Баян-Өлгий аймгийнхны бүтэн жилийн тэмцэл шүү дээ. Шинэ зүйл огт биш. Гэтэл уг захидлыг олон нийтийн бодит эрх ашиг гэх үүднээс нь авч үзээгүйгээр шүүхээс шийдвэр гаргаж байгаа нь учир дутагдалтай гэв. Тэрээр цааш өгүүлэхдээ, Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой хэрэг жилд 30 гаруй гардаг. 2008 онд гэхэд эрүүгийн хэрэг таван удаа гарсан. Сонгуулийн жил байсан. Аз болоход тэднээс шоронд суусан сэтгүүлч байхгүй. Торгуулиад өнгөрсөн. Энд нэг зүйлийг онцолж хэлэхийг хүслээ. Хэн нэгэн албан тушаалтныг шүүмжилснээрээ хэвлэл мэдээллийнхэн дандаа буруутаад байх юм бол өнөө дөрөв дэх засаглал байх, хяналт тавих үүрэг нь хөсөрдөнө. Шүүмжлэлтэй сэтгүүлзүй хөгжихөө болино. Хэрвээ шүүмжлэлтэй сэтгүүлзүй байхгүй болбол нийгэм цэвэршихгүй, эрүүл байх ямар ч нөхцөл бүрдэхгүй.

**М.ЗУЛКАФИЛ:** Юуны өмнө “Өдрийн сонин”-ы хамт олонд талархал илэрхийлье. Хэвлэлийн эрх чөлөө зөрчигдөж байгаатай холбогдуулж кампанит ажил зохион байгуулан, сэтгүүлзүйн мэргэжлийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийнхнийгээ оролцуулсан нээлттэй ярилцлага явуулж буй нь цагаа олжээ. Мөн “Өдрийн сонин” уг асуудлын хүрээнд мэргэжлийн хүмүүсээс цуврал ярилцлагуудыг нийтэлснийг та бүхэн мэдэж байгаа. Бидний авч үзэж байгаа хэвлэлийн эрх чөлөөний хуулийн зөрчил ганц нэг сонинтой холбоотой асуудал биш. Ямар ч хэвлэл байгууллагад тохиолдох зүйл. Тохиолдож ч байна. Ер нь сонин хэвлэл бичсэн нийтэл, хэн нэгэн хүнтэй хийсэн ярилцлагынхаа төлөө хариуцлага хүлээх нь утгагүй. Үүний эсрэг тэмцэх ёстой. Газар авахуулж огтхон ч болохгүй ээ.

Хэвлэлийн эрх чөлөө болон ёс зүйн асуудлаа зуун хувь шийдсэн улс орон энэ дэлхийд байхгүй. Бүх оронд тодорхой хэмжээний проблем бий. Гэхдээ тэдгээр орнууд уг эрх чөлөөг хоёр зуун жилийн турш тэмцэж байж олж авсан юм шүү. Тиймээс бидэнд тэмцэл хэрэгтэй, хамтран ажиллах чадвар хэрэгтэй. Дан ганц сэтгүүлзүйн мэргэжлийн байгууллагынхан болоод судлаачид, сэтгүүлчид төдийгүй хууль эрхийн хүмүүстэй хамтрах нь зүйд нийцнэ. Монголд хэвлэл мэдээллийн эрх чөлөө ямар түвшинд байгаа талаар судлаач хүнийхээ хувьд саналаа хэлье. Манайд хэвлэлийн эрх чөлөө нэг талаас нь аваад үзвэл чөлөөтэй юм шиг, нөгөө талаас нь харвал маш хязгаарлагдмал юм шиг. Үүнд хэвлэл мэдээллийн байгууллагууд болоод сэтгүүлчдээс шалтгаалж зүйл бас бий. Төрийн албан тушаалтан, эрх мэдэлтнүүд, улстөрчид, бизнесмэнүүд хэвлэлийн шүүмжид ихээхэн дургүй. Шүүмжлүүлэх л юм бол шүүх цагдаад ханддаг. Нуулгүй үнэнийг хэлэхэд, хууль шүүхийнхэн эрх мэдэлтнүүдийн талд шийдвэр гаргадаг. Ийм шударга бус зүйл захаасаа аваад байна. Тэгэхээр бид

ях вэ. Ямар нэгэн гарцыг л хайх хэрэгтэй болоод байгаа юм. Сэтгүүлзүй өөрөө цэвэр, мэргэжлийн, хариуцлагатай, ёс зүйтэй байх учиртай. Сэтгүүлчид маань мэргэжлийн алдаа их гаргаад байвал эрх мэдэлтнүүдийн өгөөш болсоор байна.

Надад хамтрах, дуу хоолойгоо нэгтгэх нь зүйтэй болов уу гэж бодогдож байна. Үүнд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл зэрэг мэргэжлийн байгууллагууд ихээхэн санаачилга гаргах ёстой. Хэвлэлийн консул буюу ёс зүйн зөвлөлийг яаралтай байгуулж, эхний ээлжид хэвлэлийн эрх чөлөөний хууль зөрчигдөж байгаа дээр түлхүү анхаарал хандаалах нь зүйд нийцнэ. Бид чөлөөт хэвлэлтэй ардчилсан орон гэдгээ хүлээн зөвшөөрч л байгаа юм бол баруун Европын орнуудад байдаг Хэвлэлийн консул буюу ёс зүйн зөвлөлийг яаралтай байгуулах шаардлагатай даа.

**Ц.ДАШДОНДОВ:** “Өдрийн сонин”-оос санаачлан явуулж байгаа уг нээлттэй ярилцлагын сэдэв тун чухал байна. Гол нь зүгээр нэг яриад өнгөрөх биш, цаашдаа ажил хэрэг болж өрнөөсэй гэж бодож сууна. Ер нь хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт хэвлэл гэдэг маань ярьдаг зүйл биш, хийдэг зүйл. Өдөр бүр цаг, минут бүр тэмцэж эрэлхийлж олонд хүргэдэг талбар. Тэмцэл байна гэдэг түүний эсрэг хүч байна гэсэн үг. Ёс зүй, мэргэжлийн өндөр түвшин, хариуцлагатай сэтгүүлзүй гэдэг чинь зүгээр үг төдий яриад өнгөрөх зүйл биш. Өнөө цаг үед чөлөөт хэвлэлд эв санааны нэгдэл гэдэг ойлголт үгүйлэгдээд байна уу даа. Аль нэг сонин хэвлэл дээр асуудал гарахад бүх хэвлэл мэдээллийнхэн очоод шавчих ёстой. Хэвлэлийн эрх чөлөөний тэмцэл хамгийн аюултай байдаг. Бүүр болохгүй ийм нэг арга байдаг. Телевиз радиогийнхон хэдэн минут нэвтрүүлгээ хаах, сонин хэвлэл аль нэг хуудсаа хоосон гаргахад эрх мэдэлтнүүд зарсгээд л явчихна. Буруу үйл ажиллагаа явуулж байгаа эрхмүүдэд, шударга бус хандаж байгаа хууль хяналтынханд дахиад ийм зүйл хийж болохгүй юм байна гэж бодтол нь, үндсэндээ дархлаа сайтай тэмцэл явуулах нь зөв. Өнөөдөр бол манайд сэтгүүлзүйн тийм дархлаа алга байна. Дархлаа нь юунд байна вэ гэхээр, сая Зулкафил багш хэллээ, сэтгүүлчид мэргэжлийн дээд түвшинд байж бусдын хоол болохгүй явдал. Эрх баригчид бидний алдаан дээр, сул тал дээр тоглоод байна. Мөн манай сэтгүүлчдийн холбоод олон улсын байгууллагын дэмжлэгийг авдаг байх ёстой. Энэ тал дээр хүмүүс саналаа хэлчихэв бололтой. Их олон боломж байхад ашиглаж чадахгүй л байна.

Сэтгүүлчид хэвлэл мэдээллийнхэн хүчирхэг байж, хуучнаа балбаад байхгүй дандаа шинэ үг, шинэ санаа, гарцын тухай хэлж даацтайхан ярихгүй бол биднийг нохой хуцаж байгаагаас ч дорд үзнэ. Мэргэжлийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүд ийнхүү хэвлэлийн эрх чөлөө хэрхэн зөрчигдөж байгаа талаар санал бодлоо тодорхой хэлсний дараа “Нийслэл таймс” сонины орлогч эрхлэгч Г.Дашрэнцэн өөрийн санал бодлоо илэрхийлсэн.

**Г.ДАШРЭНЦЭН:** 2000-2006 оны хооронд над дээр долоон удаа шүүхийн шийдвэр гарсан. Тухайн үед намайг өмгөөлдөг хамгаалдаг хүн байв гэхээр Х.Наранжаргал өөрийнхөө байгууллагын шугамаар хоёр хэргийг сайн хөөцөлдөж өгсөн. Мөн “Эрх чөлөө” төв байна. Эдгээр байгууллагууд анхаарч үзээгүй бол долоон хэргийг дор хаяж дөрөвт нь эрүүгийн хэрэг үүсчихсэн байх байсан. 2000-2006 онд Монголын хэвлэл “Өдрийн сонин”-оос бусад нь Н.Энхбаяр гэдэг хүнийн гарт байсан. Тэр хүн бүгдийг худалдаад авчихсан байсан. Одоо бол хэвлэл мэдээлэл олон эзэнтэй болжээ. Гол ялгаа нь үүнд байгаа юм. Сангийн яамны тухай шүүмжлэхэд Энхбаяр Улаан сайдыг дуудаад нэр төрөө сэргээлгэ гэдэг.

Надаас Сангийн сайд Улаан 280 сая төгрөг нэхэмжлээд явж л байлаа. За тэгээд Гаалийн Баатартай холбоотой хэрэг байна. Шүүхийн энэ олон байгууллагыг дамжаад явж байхад үнэхээр юм юм бодогддог. За би ч ингээд хоригдох нь ч тодорхой боллоо гэж бодогдох. Хувийн өмгөөлөгч

гэж байхгүй. Өмгөөлөгч авах мөнгө байхгүй. Тэгэхээр өнөөдөр бидэнд юу хэрэгтэй вэ гэхээр эрүүгийн шинэ хуулинд хэд хэдэн заалт оруулах. Төрийн албан хаагчийн нэр төр байдаг юм уу, үгүй юм уу. Би иргэн хүний нэр төрд халдахгүй. Харин төрд байгаа хүмүүс бидний мөнгөөр бидний өмнөөс буруу зүйл хийгээд байхаар зүгээр хараад сууж чадахгүй шүү дээ. “Нийгмийн толь” сонины асуудлаас харахад Шүүхийн шийдвэрийнхэн чинь луйварчин байсан бол одоо дээрэмчид болжээ. Тэд мэдээж дээрээ хамгаалалттай. Мөн өмгөөлөгчид гэж сайхан луйварчид байна. Тэд сониныг нэгд нэгэнгүй уншиж байна. Ялангуяа өдөр тутмын томоохон сонинуудыг. Түүн дээр хэн нэгэн баян нөхрийн тухай материал гарсан л бол тухайн хүн рүү ханддаг. Та шүүхэд нэр төрөө сэргээлгэх өргөдөл өгөөдөх гээд мөнгөө тохирдог. Бид чадалтайхан байхгүй л бол ийм том сүлжээ удахгүй хэвлэлийнхний амыг барина шүү. Өмгөөлөгч гэдэг хүн одоо нэртэй бизнесмэн юм уу, улстөрч нарыг шүүхтэй холботой зуулчлагч болсон байна шүү дээ.

Эдгээр эрхмүүд үг хэлсний дараа нээлттэй ярилцлагыг удирдаж буй “Өдрийн сонин”-ы Хариуцлагатай нарийн бичгийн дарга Д.Оюунтуяа “Нийгмийн толь” сонины эрхлэгч С.Энхтуулыг үг хэлэхийг хүссэн.

**С.ЭНХТУУЛ:** Манай сонин дээр үүссэн асуудал болоод ер нь хэвлэлийн эрх чөлөө хэрхэн зөрчигдөж байгаа талаар нээлттэй ярилцлага зохион байгуулж буй “Өдрийн сонин” болон Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, “Глоб Интэрнэшнл” төрийн бус байгууллагын төлөөллүүдэд талархаж буйгаа илэрхийлье. Эхлээд манай сонин дээр яг ямар асуудал үүсээд, өнөөдөр ийм байдалд хүрчихэв гэдгийг товч дурья.

2009 оны наймдугаар сарын 28-нд Баян-Өлгий аймгаас манай сонины нэр дээр захидал ирсэн. Засаг даргын Тамгын газрын хэсэг ажилтнуудын захидал байсан. Захидлыг нь компьютерт оруулсан учир баримт болгох зорилгоор дугтуйг нь авч ирлээ (үзүүлэв). Захидал бичигдээс “бид нэрээ тавиагүй. Хэрвээ нэр гарсан тохиолдолд Засаг дарга Хавалын нүдэнд өртөж ажил амьдралаараа хохирох болно” гэснийг нь хүндэтгээд нэргүй гаргасан. Захидал нийтэлснийхээ төлөө бид хариуцагчаар дуудагдсандаа их гайхсан. Уул нь манай сонин бус захидлыг бичсэн бичигчид хариуцагчаар дуудагдах ёстой. Үүнийг Баян-Өлгийн Засаг дарга ялгаж салгаж ойлгоогүй. Шүүхийн шийдвэр Засаг дарга Хавалын талд гарсан. Түүний нэр төрд халдсан гэх үндэслэлээр. Мөн сониноороо дамжуулж уучлал гуйхыг шаардсан. Сая гаруй төгрөг нэхэмжилсэн байгаа. Ингээд давж заалдсан. Гэвч давж заалдах шүүхээс адилхан хариу гарсан.

Сая Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга Энхтайван хоёр бүсгүйн хамт манай өрөөнд ирж, ямар ч зөвшөөрөлгүйгээр мэдүүлэг, протокол хөтөлсөн. Тэр хүн манай сонины босгоор алхсан л бол дотоод журманд маань захирагдах учиртай. Ямар ажлаар явж байгаа нь тодорхой бус.

Миний бие арга барагдахдаа тэдгээр хүмүүсийн дэргэд, үндсэндээ өрөөнөөсөө “Глоб интэрнэшнл”-ийн Х.Наранжаргал эгч рүү ярьж тусламж хүссэн. Тэгэхэд шууд гараад явчихаж байгаа юм. Энэ бүх үйл явцыг ажиглаад учир мэдэх хүмүүстэй уулзаж ярилцахад уг үйл ажиллагаа зохион байгуулалттай болоод байгаа юм биш биз гэх хардлагыг төрүүлээд байгаа.

Уг сонинтой холбоотой асуудалд зочид өөр өөрийнхөө саналыг хэлж байв. Тухайлбал, **Х.НАРАНЖАРГАЛ:** Уучлал гуйх нь буруу хэмээгээд “Манай хэвлэл мэдээллийнхэн ийм асуудалд удаан хугацаагаар тууштай тэмцэж чаддаггүй, замын голоос шантардаг. Гэвч та бүхэн шантрахгүй байгаа нь олзуурхууштай” гэв. Мөн тэрээр тусад нь өмгөөлөгч авч ажиллуулна, эрхзүйн хувьд туслахад бэлэн байгаагаа илэрхийлсэн. **М.ЗУЛЬКАФИЛ:** “Захидлын мөрөөр Баян-Өлгий руу хүн явуулах байсан. “Өдрийн сонин” монгол орны хаана л болж бүтэхгүй асуудалд гарна. Тэр бүгдэд тусгай сурвалжлагч явуулдаг. Танайх захидлаа ч нийтлээд, хажууд нь сурвалжлагаа нийтэлсэн бол

болох байсан” гэв.

Нээлттэй ярилцлага оролцсон өөр нэг сэтгүүлч нь **Б.ЖАВЗАНСҮРЭН** байв. Тэрээр Өвөрхангайн сонины эрхлэгчээр ажиллаж байхдаа хэд хоног хоригдож байсан аж. 2008 онд дунд сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн тухай бичээд буруутан болсон байна. Эхлээд Өвөрхангайн сонинд бичсэн, хэн ч тоогоогүй гэсэн. Дараа нь “Нийгмийн толь” сонины орон нутаг дахь тусгай сурвалжлагчийн хувьд уг материалаа явуулжээ. Тэгээд л асуудал үүссэн аж. “Хотод ирж сэтгүүлч нөхөддөө хандан хэвлэлийн хурал зарласан. Тэр маань харин оносон шүү. Тэгээгүй бол балрах байсан” хэмээн өгүүлэв.

“Өглөөний сонин”-ы **Х.НАМУУН-УЯНГА** ч бичсэн нийтлэлийнхээ төлөө буруутан болчихоод байгаагаа илэрхийлсэн. Уг сэтгүүлч 2008 оны есдүгээр сард “Эргүүл хамгаалалтын газрын дэд дарга залилангийн хэрэг үйлджээ” хэмээх материал сонинд хэвлүүлсэн байна. Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албаны дэд даргаас авсан мэдээлэл юм байна. Гэвч мань хүн буруутан болоод бүх шатны шүүх түүний эсрэг гарчээ. Монголд одоо хандах байгууллага бараг байхгүй боллоо гэж байсан.

Эл бүгдийн сүүлд нээлттэй ярилцлагад оролцсон зочид хэд хэдэн зүйл дээр санал нэгдэв. Тэр нь шинээр батлагдах гэж байгаа эрүүгийн хуулиас “Төрийн албан хаагчийн өндөр дээд нэр хүндийг гутаасан гэдэг зүйлийг хасах. Хэвлэл мэдээллийнхэнд эдийн засгийн хариуцлага тооцож аманд орсон дуртай тоогоо хэлдгийг болиулах” олон зүйлийн талаар ярилцсан.

Ярилцлагын төгсгөлд **Х.НАРАНЖАРГАЛ** “Ирэх арваннэгдүгээр сард хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой дугуй ширээний ярилцлага манайхаас зохион байгуулна. Тэрхүү хурлын эхлэл болгож “Өдрийн сонин”-оос нээлттэй ярилцлага зохион байгуулсан нь цагаа олсон явдал. Нийгэмд цочроо өгсөн нь дамжиггүй” хэмээн илэрхийлсэн.

**Тэмдэглэсэн Н.Гантулга**